ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 06 дугаар сарын 20

Залаа

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь | Дээд шатны байгууллагын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. Нэг: “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд: | | | | | | | | |
| 1 | 1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ | 1.1.1. Сумын нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана. | 2021 - 2024 | | | Сумын засаг даргын захирамж гарган мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний ажиллах журмыг тус бүр тодорхой зааж өгөн ажиллаж байна. Мэргэжлийн ангийн бүлэг тус бүрийн ахлагч нарыг идэвхжүүлэн ажилладаг. Мөн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд жил бүр болон шаардлагатай үед тодотгол хийн ажилладаг. | 70% | 70% |
| 2 | | 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрүүл мэндийн | 2021 - 2024 | 35,500,000 | | Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрүүл мэндийн салбарын хэмжээний шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног | 90% | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | салбарын хэмжээний шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нөөцийг бүрдүүлнэ. | | | | төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг цаг тухай бүрэн эрүүл мэндийн газар болно аж ахуй нэгж хандиваар бүрдүүлсэн. | | |
| 3 | | 1.1.3. Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх, | 2021 - 2024 | 4.500.000 | | Ковид-19" халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх, сэрэмжлүүлэг мэдээллээр хангах ажлыг сумын цахим хаяг болно явуулын зар явуулж бүрэн хэрэгжүүлсэн ажилласан. | 100% | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэрэмжлүүлэг мэдээлэлээр хангах ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна. | | | | | | |
| 4 | | 1.1.4. “Ковид¬¬-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг 2021 онд Эрүүл мэндийн төвтэй хамтран хийлгэсэн ба эрсдэл бага үнэлэгдсэн. | 100% | 100% |
| 5 | | 1.1.5. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, тусгаарлах болон эмчлэн тусгаарлах байруудын бэлэн байдлыг шуурхай хангаж эмч | 2021 - 2024 | | | Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг тогтмол явуулдаг. Сумын цахим хуудсанд 2023 оны эхний 6 сарын байдлаар Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах 6 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Халдварт өвчин гарсан тохиолдолд тусгаарлах болон эмчлэх 10 ортой байр бэлдэж шаардлагатай тохиолдолд соёлын төв болон сургуулийн дотуур байрыг дайчлан оролцуулах ажлыг зохион байгуулан, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан ажиллаж байна. Эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг гарган 3-4 сарын нөөцөөр бэлдэн ажилласан. | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга барилд сургах ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж ур чадварыг нь дээшлүүлэн аюул эрсдлээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээр хохироохгүй байх арга хэмжээг авч ажиллана. | | | | Ажлын байрны сургалтыг зохион байгуулж, халдварт өвчин гарсан тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаи мэдээлэх схемийн дагуу кейс дээр ажиллаж ажилчдын бэлэн байдлыг сайжруулах ажлыг улиралд нэг удаа хийсэн. ЭМС-ын 536,537,538,539-р тушаалын дагуу ажиллаж байна. Мөн хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж, зөв тайлах ажлын байрны сургалтыг Халдвараас сэргийлэх хяналтын баг хариуцан улиралд нэг удаа тогтмол хийж хэвшсэн. Голомтын болон эцсийн ариутгал халдваргүйтгэлийн ажлын байрны сургалтыг ариутгагчид хийж ажлын чанарыг сайжруулан ажиллаж байна. Ард иргэдэд ковид-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 зурагт хуудас болон эрүүл мэндийн санамж хуудас байршуулсан. Хуваалцсан болон тандалт авсан иргэдийн тоо-185, төрийн албан хаагч болон хувийн хэвшлийн байгууллагуудад тараасан санамж хуудас 22, багийн дарга нартай хамтран багийн иргэдийн хурал болон тэмдэглэлт өдрүүдээр нийт 450 иргэнд гарын авлага тарааж, эрүүл мэндийн боловсрол олгосон. Нийгмийн эрүүл мэндийн сургалтын үр дүнд он гарсаар ковид-19 халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй нь сургалт сурталчилгаа болон салбар дундын хамтын ажиллагаа сайн байгааг харуулж байна. | | |
| 2. ХОЁР. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд | | | | | | | | |
| 6 | 2.1. Эрүүл иргэн -Ирээдүйн үнэт зүйл | 2.1.1. Төсөвт албан байгууллагуудыг ажлын байран дээрээ артерийн. | 2021 - 2024 | | | Хүлээгдэж байна. | 0% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | даралт, биеийн жингээ хэмжих, эрүүл мэндээ хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжийг бий болгон ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ | | | | | | |
| 7 | | 2.1.2. Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаН, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ. | 2021 - 2024 | | | Эм эмнэлгийн хэрэгслийн шаардлагатай тоног төхөөрөмж багажийн судалгааг гарган эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээнд хэрэглэхээр төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Одоогийн байдлаар шээсний шинжилгээний аппарат нэн шаардлагатай байна.Тендерийн эмийг гэрээт эмийн сангуудаас захиалгын дагуу авч цаг тухайд нь тооцоог дуусган ажилласан. Тус сум нь 2 эмийн сантай. Эдгээр эмийн сангууд ард иргэдэд эмийн зохистой хэрэглээ болон дархлаажуулалтын ажлыг тусгасан төлөвлөгөөний дагуу нийт 2 удаа хийсэн. Нийт 124 иргэнд "Эмийн зохистой хэрэглээ" сэдэвт сургалтыг хийж, бүртгэл хөтлөн витамин тарааж, гарын авлага өгч ажилласан. Эмийн чанар аюулгүй байдалд улиралд 1 удаа дотоод хяналт хийсэн. Шалгалтын явцад зөрчил илрээгүй. Эмийн хугацаатай холбоотой ард иргэдээс нэг гомдол ирсэн. Үүнийг газар дээр нь шалгаж сануулах арга хэмжээ авч ажилласан. | 70% | 70% |
| 8 | | 2.1.3. Иргэдийн зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс | 2021 - 2024 | 465.000 | | Баянхонгор аймгийн Бодь-Лаб лабораторитой хамтран гэрээ хийж байгууллага дээрээ авчирч 14 албан хаагчийг бүрэн шинжилгээнд хамрагдаж 1 албан хаагч чөлөөтэй өөр газар явж байсан тул хамрагдаагүй, шинжилгээ | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг зохион байгуулах замаар өвчлөлийг бууруулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ. | | | | өгсөн албан хаагчид шинжилгээний хариуг уншуулж оношоо мэдэж эмчлүүлэх боломжоор хангаж ажиллаа. 3 хүний онош эмчилгээ хийлгэн дахин шинжилгээ өгөх шаардлагатай гэсэн эмчилгээ аван дахин оношилгоонд аймагт хамрагдаад ирсэн. | | |
| 9 | | 2.1.4. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд нийцсэн, хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Сумын эрүүл мэндийн төвд Уламжлалт анагаах ухааны чиглэлээр төгссөн эмч болон эмнэлгийн мэргэжилтэн байхгүй. Цаашид хүний нөөцийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангаан тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх саналыг Сумын ЗДТГ-т болон сумын иргэдийн хуралд хүргүүлэхээр төлөвлөж байна. | 30% | 30% |
| 10 | | 2.1.5. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, резидент сургалтад хамруулах, ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Шинэжинст СЭМТ-нь нийт 22 орон тоотой ажиллаж байна. Их эмч-3 ерөнхий мэргэжлийн эмч нар ажилладаг. СЭМТ-д хүүхэд, эмэгтэйчүүд, эхо, дотрын төрөлжсөн мэргэжлийн эмч нар нэн шаардлагатай байна. Иймээс мэргэжил дээшлүүлэх резидент эмч нарын сургалтыг шийдвэр гаргагч нар бодлогын түвшинд шийдэж өгөхийг хүсэж байна. Эмнэлгийн дунд мэргэжилтнүүдээс ахлах зэргийг 2 сувилагч авсан. 2023 он гарсаар 1 багийн эмч, 1 сувилагч ахлах зэргийн шалгалт өгөхөөр материалаа бүрдүүлэн ЭМХТөвд хүргүүлсэн. Ур чадварын нэмэгдлийг ажлыг нь дүгнэн 1 бага эмчид 25%-р бодож олгосон. | 30% | 30% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | | 2.1.6. Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж эм эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт үнийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Сумын ЭМТөв нь "Мандалгоо" эмийн сантай 1 жилийн хугацаатай гэрээ хийж ажиллаж байна.Тендерийн эмийг "Монфа" трейд ХХК, "Тэгш-Анар" ХХК-аас захиалгаар авч ажиллаж байна. Эмийн үнийн уян хатан байдалд дүн шинжилгээ хийж ажилладаг. Эмийн хадгалалт тээвэрлэлт дээр хяналт хийж, хугацаа дууссан эмийн жагсаалтыг сар бүр гаргаж мэдээллийг солилцож ажиллаж байна. | 90% | 90% |
| 12 | | 2.1.7. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ | 2021 - 2024 | | | Цаг гаргая аяны хүрээнд зохион байгуулагдаж буй өглөөний дасгал, нарны алхалт, дугуй унах Шинэжинст суманд 4 сарын 24-нээс эхэлж өглөөний дасгалаа хийлгүүлж ард иргэдийнхээ илүүдэл жин, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллаж байна.Цаг гаргая аяныхаа хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулсан. Өглөөний дасгалыг 07:08:30 цагт соёлын төв болон ЗДТГ-ын талбай дээр хийлгүүлж байна. | 70% | 70% |
| 13 | 2.2. Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг хангах | 2.2.1. Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хооллолтыг дэмжих сургалт сурталчилгааг тогтмол хийж хүн амын дундах хоол хүнсний далд | 2021 - 2024 | | | Хүн амын хоол тэжээлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Эрүүл хооллолт" "Давсаа хасъя" сэдэвт сургалтуудыг 1,2,3,4 багийн нийт 150 иргэдэд хийсэн. Сургалтын өмнөх мэдлэг 35% байсан бол сургалтын дараах мэдлэгийн түвшин 68% болж өссөн. Сургалтын үеэр их эмч нар эрүүл хооллолт, эрүүл хүнс, хүнсэнд агуулагдах эрдэс витамины орц найрлагын талаар зөвлөгөө өгч ажилласан. Цэцэрлэг болон ЕБС-ийн сурагчдын гал тогоонд нэг хүүхдэд ноогдох хоолны орц, амт чанар, өнгө, давтамж, төлөв | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | | чихэр тослогийг бууруулан эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг багасгах замаар илүүдэл жингээс сэргийлэх, бөөр зүрх судасны өвчлөлийг бууруулан үр дүнг тооцно. | | | | байдалд шалгалт хийж, эрүүл ахуйн нөхцөл байдлыг дүгнэсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил гараагүй. Хоол үйлдвэрлэгч нар бүгд шаардлагатай нарийн шинжилгээнд бүрэн хамрагдсан байна. | | |
| 14 | | 2.2.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн хүлээгдэл чирэгдлийг бууруулна. | 2021 - 2024 | | | Сумын ЭМТөвд 3 хүний бүрэлдэхүүнтэй чанарын баг ажиллаж байна.Ард иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй хүргэх чанар аюулгүй байдлын төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны ЭМТҮЧАБСТ-өөг боловсруулан ЭМХТөвд хүргүүлж батлуулахаар бэлдэж байна. ЭМЯ -аас хэрэгжүүлж буй хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой иргэдээс ирсэн гомдол санал гараагүй. Үйлчлүүлэгч нарт ээлтэй орчин бүрдүүлэх, анагаах ухааны орчин үеийн шинэ дэвшилтэд нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Төлөвлөгөөний биелэлт 65%-тай байна. | 70% | 70% |
| 15 | 2.3. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын | 2.3.1. Багш, сурагчдын сурч хөгжих, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, багшийн | 2021 - 2024 | төсвөөс | | СӨБ-ын багшаар мэргэшсэн 4 мэргэжлийн багш үндсэн бүлэгт багшлаж хүүхдэд ээлтэй эко орчинг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна. | 90% | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжлийн болон багшлах ур чадварыг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 16 | үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ. | 2.3.2. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжинэ. | 2021 - 2024 | | | Хүлээгдэж байна. | 0% | 0% |
| 17 | | 2.3.3. Сургууль, цэцэрлэг, соёлын төвийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын засвараар үе шаттай хангаж, удирдлагын чадавхийг сайжруулна. | 2021 - 2024 | | | Сургуулийн нийт 17 ангид урсгал засварын ажил хийгдсэн. Нэг ангийг 310000 төгрөгөөр буюу нийт 5270000 төгрөгийн өртөгтэйгөөр засварласан. Байгууллагын урсгал засварын зардал байхгүй тул уг зардал мөнгийг анги даасан багш, эцэг эхийн хамтын санаачилгаар дундын сангаас зохицуулсан. Мөн спорт заалны урсгал засварын ажлыг заалны өөрийн орлогоор буюу 545000 төгрөгөөр хийсэн. | 50% | 50% |
| 18 | | 2.3.4. Боловсролын байгууллагуудын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ. | 2021 - 2024 | төсвөөс 24.496.000 | | Сумын хэмжээний 2-5 настай нийт 235 хүүхдээс 130 хүүхдийг үндсэн бүлэгт, 19 хүүхдийг явуулын бүлэгт хамруулан 65%-ийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан ажиллаа. | 70% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | 2.3.5. “Сайн багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | 2020 онд хэрэгжилтийн хугацаа дууссан. | 100% | 0% |
| 20 | | 2.3.6. “Хүүхдийн амьдрах ухааны төв, хөдөлмөр зуслан“ –д сурагчдыг хамруулна. | 2021 - 2024 | | | 2020 онд хэрэгжилтийн хугацаа дууссан. | 100% | 0% |
| 21 | | 2.3.7. Сургуулийн өмнөх боловсрол, сургуульд “Авьяас” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | 2020 онд хэрэгжилтийн хугацаа дууссан. | 100% | 0% |
| 22 | | 2.3.8. Орон нутагт дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр “Суралцаж байгаа оюутнуудыг боловсролын зээлийн сан“-д болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна. | 2021 - 2024 | | | Орон нутагт дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр “Суралцаж байгаа 20 оюутнуудыг "Амралтаараа ажиллая" хөтөлбөрт хамруулах бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж Эрдэнэмонгол ХХК-тай гэрээ байгуулан хэрэгжүүлж эхлэхээр төслийг боловсруулсан. Энэ оны 06 дугаар сарын 20-оос 8 дугаар сарын 20 хүртэл цалинтай хэрэгжих хөтөлбөр юм. | 70% | 70% |
| 23 | | 2.3.9. “Монгол ухаан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | ХЭРЭГЖИЛТИЙН ХУГАЦАА ДУУССАН. | 100% | 0% |
| 24 | | 2.3.10. Сурагчдын оюуны хөгжүүлэх, бие даан суралцах, | 2021 - 2024 | | | 2022-2023 оны хичээлийн жилд даам, шатар, волейбол, теннис, уран зураг, үндэсний бөх, математик, англи хэл, үндэсний бичгийн дугуйлангууд хичээллэж сургуулийн 428 | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, уралдаан, тэмцээн, олимпиад зохион байгуулах. Санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | | | | сурагчдыг тэгш хамруулан оролцууллаа. Онцлох амжилтууд: Волейболын дугуйлангийн сурагчид Баянхонгор аймгийн аварга шалгаруулах U14 тэмцээнд Тэргүүн байр, Баянхонгор аймгийн аварга шалгаруулах U13 тэмцээнд Гутгаар байр, Баянцагаан суманд зохион байгуулагдсан Говийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн Гутгаар байр Даамны дугуйлан: Баянхонгор аймагт зохион байгуулагдсан хүүхдийн VII их наадмын сорилго тэмцээн 8б ангийн сурагч Г.Нандин-Эрдэнэ 5-дугаар байр Уран зураг: Баянхонгор аймагт зохион байгуулагдсан уран зургийн уралдаанд 9б ангийн сурагч Р.Элбэгзаяа гутгаар байр Үндэсний бичгийн дугуйлан: Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Шударга уншигч уралдаан 8б ангийн сурагч Ж.Энхмэнд 5-дугаар байр, Кенгеру ОУ-ын олимпиадад Ю.Амармандах Л.Түвшин заяа нар амжилттай оролцож 3-дугаар байрт орсон зэрэг тус тус амжилтуудыг гаргалаа. | | |
| 25 | | 2.3.11. “Хос бичигтэн”, “Англи хэл”, “Робокон-Баянхонгор”,дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | | | Робокон хөтөлбөрийн хэрэгжилт 2020 онд дууссан. Англи хэлний сургалтын чанар 7, амжилт 28, гүйцэтгэл 38 хувьтай байна. Мөн англи хэл үндэсний хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдад 14 хоногийн 28 цагийн сургалтыг зохион байгуулж нийт 42 хүн хамрагдсан. Үндэсний хөтөлбөр-3 хүрээнд төрийн албан хаагчдын дунд “Нэрийн хуудас”-аа үндэсний бичгээр бичих уралдаан зарлаж нийт 5 байгууллагын 85 төрийн албан хаагч нэрийн хуудастай болсон. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдад 14 хоногийн 28 цагийн сургалтыг зохион байгуулж нийт 42 хүн | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдаж мэдлэгийн түвшинг үнэлсэн. | | |
| 26 | | 2.3.12. Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлж шагнаж урамшуулна. | 2021 - 2024 | | | Төрөлжсөн олимпиадын 2-ын давaанд багш суралцагчдаа оролцуулсан. Математикийн олимпиадын 6,8-р ангийн төрөлд сурагч Л.Түвшинзаяа, Ю.Амармандах нар 4-р байр, Олон улсын Кенгеру олимпиадад цахимаар оролцож Л.Түвшинзаяа 3-р зэргийн диплом, Ю.Амармандах 3-р зэргийн дипломын болзол хангажээ. Бага ангийн багш мэргэжлээр суралцаж байгаа 3, технологийн багшаар суралцаж байгаа 1 оюутан байна. Төрөлжсөн Aplus.mn цахим сургалтад багш нар бүрэн хамрагдаж батламжаа авсан. Үндсэн сургалтад 1 дэх жилдээ ажиллаж байгаа 3, 5 дахь жилдээ ажиллаж байгаа 1 багш сууж батламжаа авсан байна. Ажлын байранд багш нарын хууль эрх зүй, үндэсний бичиг, англи хэлний сургалтыг төлөвлөгөө боловсруулан тогтмол явуулж байна. Энэ хичээлийн жилд өөрийн эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан, бэлтгэсэн шавь нар нь амжилт гаргасан 9 багшид 10-25 хувиар үндсэн цалингийн нэмэгдэл тооцож урамшуулал олгосон байна. Багш нарынхаа хүрээнд бага дунд ангийн заах аргын нэгдэл, монгол хэл, математик , байгалийн ухааны мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллалаа. Мөн тэргүүлэх зэрэгтэй ахмад багш Х.Тунгалаг багш 1-р ангийн болон бага насны хүүхэдтэй ажиллах арга зүй, Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллага хамт олны ёс зүй сэдвээр сургалт ярилцлага, холимог бүлгийн сурагчдад хичээл заах, зочинтой хичээл, хичээл судалгаа, даалгавар боловсруулах арга зүй чиглэлээр хамтарч ажиллав. Мөн 1-5 дахь жилдээ ажиллаж залуу | 90% | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багш нарт ахмад багшийн зөвлөн туслах, дадлагажуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг. ХЭААБ-ын сарын аянд бүтээлч ажлын уралдаан зарлаж багш Ж.Пагма, Э.Дүүрэнхундага, Д.Ганболор нарыг үндсэн цалингийн 10-25 хувиар шагнаж урамшууллаа. Энэ хичээлийн жилд 1-р ангид элсэн орсон 5,9 ангийг төгсөж байгаа сурагчдын тайлант өдөрлөгийг эцэг эх асран хамгаалагчдад танилцуулсан. | | |
| 27 | | 2.3.13. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим, сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ. | 2021 - 2024 | | | "Алхам алхмаар " аяны мэдээллийг тухай бүрд нь Шинэжинст сумын насан туршийн боловсролын группэд байршуулж байна. 8а ангид нэг удаа хичээл орж Алхам алхмаар цахим хуудаст нэгдүүлж 20 сурагчаар тест сорил туршилт хийж би ямар мэргэжилтэй болбол зохиох талаар сорил авлаа. "Миний эрхэмлэх үнэт зүйл, миний мэргэжил постер уралдаан"-д 9-р ангийн 5 сурагчийн постер, 8-р ангийн Эссэ бичлэгт 2 сурагчдын бүтээлүүдийг дараагийн шатанд оролцуулсан. 6-9 ангийн сурагчдын дунд Волейболын тэмцээн, Усны өдөр, Мазаалайн өдрүүдийг угтан ханын сонин хийх ажлыг 2 удаа зохион байгуулсан. Нийт давхардсан тоогоор 14 анги ханын сонин хийж оролцсон. Үйлдвэрчний эвлэлийн дарга Ц.Хуяг "Хөдөлмөрийн тухай хууль"-аар захиалгат сургалтыг 2023 оны 02 сарын 16нд соёлын төвд нийт 54 төрийн албан хаагч оролцов. Сумын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарч "Нандин холбоо" арга хэмжээн дээр "Эмэгтэйчүүд гэж хэн бэ" "Эмэгтэйчүүд гайхамшигт ертөнц" гэсэн лекцүүдийг 68 иргэнд уншлаа. Дэлхийн мөнгөний долоо хоног Цахим сургалтад 20 | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурагчдыг хамрууллаа. Мөн ХААН БАНК-тай хамтарч 7-9 ангийн нийт 58 сурагчдад "Мөнгө, мөнгөний үнэ цэнэ", "Санхүүгийн боловсрол" сэдвээр сургалт орсон. Насан туршийн боловсролын 5 чиглэлээр нийт 19 төрлийн сургалтыг 505 иргэнд явуулсан. | | |
| 28 | 2.4. Иргэдийн нийгмийн баталгааг хангах | 2.4.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана. | 2021 - 2024 | | | 2022 онд Сайн дурын даатгалд 272 даатгуулагч даатгуулж 109777440 төгрөгийн орлого оруулсан. 2023 оны эхний хагас жилийнд 285 даатгуулагч хамрагдан эхэлж байна. Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлд нийт 23 эхийг хамруулсан Эхийн хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлд нийт 21 эхийг хамруулан ажиллаж байна. Үүнээс Малчин – 295, Хувиараа хөдөлмөр эрхлэгч – 22, Оюутай – 12 Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 329 даатгуулагч хамруулсны 295 нь "Малчин" байгаа нь сайн дурын даатгалд хамрагдаж байгаа иргэдийн 89%-ийг эзэлж байна. Гэрээнд заасны дагуу төлөх шимтгэлийг тооцон авч 285 даатгуулагч хамруулж 2022 оны 12 дугаар сарын 06-ны байдлаар 105,810,700 төгрөгийн орлого оруулсан. 73,952,981 төгрөг хуримтлагдсанаар 70,1 хувиар биелүүлээд байна. Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлд нийт 21 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 5 823 630 төгрөгийн орлого оруулахаас 3 852 365 төгрөгийг хуримтлагдсанаар 66 хувиар биелүүлээд байна. Эхийн хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлд нийт 23 эхийг хамруулж эхний хагас | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн төлөвлөгөөнд 4,922,580 төгрөгийн орлого оруулахаас 2,684,265 төгрөгийг хуримтлагдсанаар 54 хувиар биелүүлээд байна. Эрүүл мэндийн даатгалд иргэдийг хамруулж 11,188,620 сая төгрөгийн орлого оруулахаас 259 даатгуулагчдыг хамруулж 8 347,000 төгрөгийн орлого хуримтлагдсанаар 74,6 хувиар биелүүлээд байна. | | |
| 29 | | 2.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | | | Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэний мэдээлэл санал гомдолд судалгаа явуулах, тандалт хийх зэргээр тулж ажиллан, сэтгэл зүйн зөвлөгөө, чиг баримжаа олгож ажилласнаар хэвийн нөхцөлд амьдрах үндсийг бүрдүүлсэн бөгөөд түр ажлын байраар 2 иргэнийг хангаж өгч ажиллуулж байна. | 70% | 70% |
| 30 | | 2.4.3. Ажилтай орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж 25-аас доошгүй иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдана. | 2021 - 2024 | | | Зорилтот бүлгийн 2 иргэн, энгийн 2 иргэн түр ажлын байраар хангагдсан. 20 оюутан түр ажлын байраар хангагдахаар гэрээ байгуулагдсан. | 70% | %70 |
| 31 | | 2.4.4. Ахмадын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж тухайн ахмад настангуудын өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | | | Ахмадын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуульд 3 багш, ЗДТГ-т архив бичиг хэргийн ажилтанд туслуулахаар 1 ахмад, холбооны салбарт 1 зэрэг 5 хүнийг цалинжуулан ажиллуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна. | 70% | 70% |
| 32 | | 2.4.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн | 2021 - 2024 | | | Зорилтот бүлгийн 2 иргэний мэдээлэл санал гомдолд судалгаа явуулах, тандалт хийх зэргээр тулж ажиллан, сэтгэл зүйн зөвлөгөө, чиг баримжаа олгож ажилласнаар хэвийн нөхцөлд амьдрах үндсийг бүрдүүлэн, түр | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлнэ. | | | | ажлын байраар хангаж өгч ажиллуулж байна. "Амралтаараа ажиллая" оюутан хөтөлбөр хэрэгжүүлж 20 оюутан хамрагдахаар бүртгүүлээд байна. | | |
| 33 | | 2.4.6. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2021 - 2024 | 0 | | Зорилтот бүлгийн иргэн Н-ын аж байдалтай танилцан, түүнд анхаарал халамж дутагдаж байгааг илрүүлсэн бөгөөд хамтарсан багийн хурлаар хэлэлцэн, өөрт нь таарсан хөдөлмөр эрхлүүлж, өрх гэрийн орлогоо нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн шийдвэр гарган, орон нутагтай хамтран ажиллаж байгаа аж ахуйн нэгжид хүсэлт хүргүүлсэн бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байраар хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санал ирүүлсэн бөгөөд 6 дугаар сарын 01-нээс ажлын байранд гарах боломж бүрдсэн. Мөн иргэн Д-гийн гэр бүлийн нөхцөл байдал дээр ажиллаж , сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид ажлын байранд бүртгүүлснээр угаагчийн ажилд орж, өрхийн орлогоо нэмэгдүүлж байна. | 70% | 70% |
| 34 | | 2.4.7. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж хүний хөгжил, хамгааллыг сайжруулна. | 2021 - 2024 | | | Дэлхийн "Гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан сумын хэмжээнд зохион байгуулж байгаа "Гэр бүлийнхээ гишүүний тоогоор мод тарья" аяны хүрээнд хүн бүр байгаль хамгаалах үйлсэд гэр бүлээрээ нэгдэж , хайртай ханьдаа, хайртай үрдээ, хайртай аав, ээждээ зориулж хайр шингээсэн амьд байгалийг бүтээх ариун үйлсэд ам бүлээрээ чин сэтгэлээсээ оролцож, түүгээрээ бахархах, дурсамж бүтээх, гэр бүлийн нандин харилцааг бэхжүүлэх зорилгоор уралдаан зохион байгуулж 35 өрх өрхийн хэмжээндээ 260 мод тарьсан үзүүлэлттэй. | 70% | 70% |
| 35 | | 2.4.8. Хүн амын | 2021 - | | | "Ураг удмаа мэдье" сэдвийн хүрээнд ах | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлнэ. | 2024 | | | дүүсийн хүрээллээр нь баг бүрдүүлэн тэмцээнд оролцуулж, удам судраа мэдэж, авах, ураг төрлөө судалж, танин мэдэх, зан төлөвшилд эерэг нөлөөлөл үзүүлэх, тэдний үе удмын харилцааг бэхжүүлэх зорилготойгоор сургуулийн сурагчид, насан туршийн боловсрол эзэмшигчид буюу 17 хүртэлх /2006.06.01-нээс хойш төрсөн/ насны хүүхдүүдийг нас насны онцлогоор оролцуулах боломжийг бүрдүүлж 2023.06.10-нд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 68 хүүхэд ах дүүсийнхээ хүрээллээр оролцсон.Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх ажил болсон гэж дүгнэж байна. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын байгууллагаас мэргэжилтэн удам судар, ургийн дэвтэр хөтлөх талаар сургалт зохион байгуулж 125 иргэн хамрагдан мэдээлэл авсан. | | |
| 36 | | 2.4.9. Угийн бичиг хөтлөх аян зохион байгуулна. | 2021 - 2024 | | | Угийн бичиг хөтлөх аянг аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж, манай суманд Гэр бүл хөгжлийн газрын мэргэжилтнүүд ирж ажилласан бөгөөд “Угийн бичиг хөтлөх нь” сэдвээр М.Батцэнгэл 158 иргэнд сургалтыг хийсэн. | 50% | 50% |
| 37 | | 2.4.10. Иргэдэд эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоно. | 2021 - 2024 | | | Иргэдэд эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр аймгийн Гэр бүл залуучуудын хөгжлийн газраас мэргэжилтэн ирж сургалтыг зохион байгуулсан бөгөөд 125 иргэн хамрагдсан байна. Эрүүл аж төрөх үндэс нь байгаа газрын орчныхоо хог хаягдлыг сар бүр түүж хэвших гэсэн аян хэрэгжүүлж Байгууллага бүр-Цэвэр орчин бүрдүүлэх, хамт олноороо нэг сайн дурын ажил хийхээр төлөвлөсөн. “Хүнийг хөдөлмөр хөтөлнө” | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгын дагуу нийгмийн бодлогоор хүний хөгжлийн талаарх нөлөөллийн ажлыг байгаль орчинтой уялдуулан холбон өгөх зорилгоор "Нэг хамт олон-Нэг сайн дурын ажил" аяны хүрээнд хог хаягдлаа цэвэрлэх, цэвэр орчинд ажиллаж амьдрах ажлыг эхлүүлсэн. Сумын төвд үйл ажиллагаа эрхэлдэг 6 албан байгууллага, клонкууд, банкууд, дэлгүүр, аж ахуйн нэгж хоршоо, ахмадын байгууллага зэрэг нийт 25 хамт олон сумын төвийн нийтийн эзэмшил газрыг хувиарлан авч хог хаягдлын их цэвэрлэгээг сар бүр хийж хэвшээд байна. Хагас жилийн хэмжээнд 3 удаагийн их цэвэрлэгээнд давхардсан тоогоор 450 иргэн хамрагдсан байна. | | |
| 38 | 2.5. Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ | 2.5.1. Сумын нийт ард иргэдийн дунд соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна. | 2021 - 2024 | 0 | | Сумын нийт ард иргэдийг хамарсан үйл ажиллагааг эхний хагас жилийн байдлаар хамтарсан болон сумын ардын авьяастнуудын тоглолтыг 6 удаа, нийтийн цэнгээнт бүжиг 10 удаа, нийтийг хамарсан хурал зөвлөгөөн болон бусад арга хэмжээ 15 удаа тус тус зохион байгууллаа. | 70% | 70% |
| 39 | | 2.5.2. Соёлын биет ба биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, ард иргэдэд сурталчилан таниулна. | 2021 - 2024 | 0 | | Аймгийн хамгаалалтад байдаг Сүүжийн чулуун дурсгал, Индэртийн хадны дурсгал, Бичигт ханан, Ногоон цав, сумын хамгаалалтад байгаа Дархан булаг, Хонгор тайжийн булш, Залаа хайрхан, Зүлэгтийн дурсгал, Их саманд хайрхан, Суварган сухай, Тахилгат хайрхан, Урд жаргалант, Хан уулын дурсгал, Хашаат гэх мэт түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг ойролцоо нутгалдаг айл өрхүүдэд болон багийн Засаг дарга байгаль хамгаалагч нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллаж байна. | 70% | 70% |
| 40 | | 2.5.3. Соёлын | 2021 - | 200,000 | | Бүх нийтийг Соёлын боловсролыг дээшлүүлэх | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, хандлагыг өөрчилж "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2024 | | | зорилтын доор Уртын дууг хүүхэд залуучуудад сургах түгээн дэлгэрүүлэх залуу хойч үедээ өвлүүлэх зорилгоор Уртын дууны багш Д.Бямба, сумын уртын дууч Д.Ганбат нараар багшлуулан сургуулийн насны 10 хүүхдэд 3 дууг бүрэн зааж сургаад байна. Мөн номын сангийн дэргэдэх Утга зохиолын дугуйланг аймгийн Зохиолчдын холбооны нарийн бичиг Х.Тунгалаг багшаар удирдуулан хичээллүүлж байгаа бөгөөд уг дугуйланд ЕБСургуулийн 3-9 дүгээр ангийн 18 хүүхэд хамрагдаж байна. | | |
| 41 | | 2.5.4. Урлаг соёлын чанар хүртээмжийг дээшлүүлж, үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл сайжруулна. | 2021 - 2024 | 20 сая | | Манай байгууллага нь 2020 онд ашиглалтад орсон шинэ барилга тул иргэдэд соёлын үйлчилгээг үзүүлэхэд чанар хүртээмжийн хувьд маш сайн. 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20 сая төгрөгийн хөгжмийн зэмсэг худалдан авч ард иргэд хүүхэд багачуудад дугуйлан сургалт явуулж байна. Үүнд: Ёочин-2ш, Ятга-2ш, 16-н утастай ятга-4 ш, хуучир-1ш, үкүлэлэ-10ш, морин хуур-5ш, ямаха -1ш, баян хуур-1 ш гэх мэт хөгжмийн зэмсгээр баяжилт хийгдсэн байна. | 100% | 100% |
| 42 | | 2.5.5. Иргэдийн ном унших дадал хэвшлийг нэмэгдүүлж, номын сан болон орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг сайжруулна. | 2021 - 2024 | 0 | | Хүүхэд залуучуудын ном унших дадал хэвшлийг сайжруулах зорилгоор сургуулийн номын сантай хамтран 6-9 дүгээр ангийн хүүхдэд ангиар нь хуваарь гарган 3 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 1-ний хүртэл хугацаанд танхимаар ном уншуулж байна. Мөн ард иргэдэд гэрээр байнга ном олгож байна. | 70% | 70% |
| | | | | 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | |
| 43 | 3.1. Газар тариалангийн | 3.1.1. Төмс хүнсний ногоо, | 2021 - 2024 | | | Сумын хэмжээнд нийт 4.5га-д тариалалт хийгдсэн. 19 өрх тариалалт хийсэн. | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцож цаашид төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ | | | | Тариалалтын мэдээ эцэслээгүй учир нэмэгдэх магадлалтай. | | |
| 44 | салбарын үйл ажилагааг дэмжиж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлнэ. | 3.1.2. Нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ | 2021 - 2024 | | | "Баянхонгорт үйлдвэрлэв-2023" каталогт сумын брэнд бүтээгдэхүүн болох аянчин, жинчин, бабуу жинчингийн зургийг тайлбарын хамт оруулсан. Ингэснээр гадна дотны олон иргэд ямар бүтээгдэхүүн байгааг мэдэж худалдан авалт нэмэгдсэнээр брэнд бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, борлуулалтын орлого нэмэгдэх болно. Мөн сумд ингэн фермерийн аж ахуй нээгдвэл ингэний сүү, сүүн бүтээгдэхүүнээр нутгийн брэнд бүтээгдэхүүн гаргах боломжтой. | 70% | 70% |
| 45 | | 3.1.3. Газар тариалан эрхлэгчдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг лизингийн болон зээлийн бодлогоор дэмжинэ. | 2021 - 2024 | 68000000 | | 2022 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай анжис бүхий тракторыг тендер зарлан нийлүүлэгчийг шалгаруулж техникийн тодорхойлолтыг үндэслэн хүлээн авч ашиглаж байна. Тус тракторыг Эхийн голын тариалан эрхлэгч Д.Булгантамирт хүлээлгэн өгч хариуцуулсан. | 90% | 90% |
| 46 | | 3.1.4. Стандартын шаардлага хангасан хүлэмж, | 2021 - 2024 | | | Хүлэмжийн тариалалт эрхэлдэггүй. Сумын хэмжээнд өөрийн эзэмшлийн зоорьтой 5 өрх байдаг. | 0% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зоорийн тоог нэмэгдүүлэн ашиглалтыг сайжруулна. | | | | | | |
| 47 | | 3.1.5. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн сумын хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр хангахыг зорьж, Эхийн гол, Уртын гол болон бусад булаг шандыг түшиглэн тариалалтыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | | | Эхийн голд 17 өрх, Уртын голд 1 өрх, Эрдэнэшанд багт 1 өрх өрхийн тариалалт хийсэн. Нийт тариалсан талбай 4.5га. | 70% | 70% |
| 48 | 3.2. Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийг чадавхжуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн эрүүл бүс статусаа бататгана. | 3.2.1. . Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл бүс статусаа бататгана. | 2021 - 2024 | Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын ажилд сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 221440 мянган төгрөгийг зарцуулсан. | | 1. “Мал амьтны гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/218 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/36 тоот захирамжийг боловсруулан батлуулж хавсралтаар ажлын хэсэг, зардлын тооцоог батлуулан маршрут гарган ажиллалаа. Нийт 396 км явах шатахуун, масло зэргийн зардал 221440 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлүүлэн ажлын хэсэг хамтран ажиллалаа. Дархлаажуулалтад үхэр сүргийг 05 дугаар сарын 02, 09,10-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 2 чиглэлийн 41 өрхийн 267 үхрийг хамруулсан. Үхэр тариулсан 31 малчин өрхүүдээр явж | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дархлаажуулалтын хяналтыг тавьж ажиллалаа.Малчин өрхүүдээр орж ажиллахдаа аймаг, сумын Засаг даргын захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаал зэргийг танилцууллаа. Дархлаажуулалтын санхүүгийн баримт сумын Засаг даргын захирамж,албан тоот, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэхэмжлэх, тарилгын акт, жагсаалт, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, тасгийн илтгэх хуудас, улсын байцаагчийн дүгнэлт, зөвлөлийн хурлын тэмдэглэл , маршрут зэргийг бүрдүүлэн аймгийн Мал эмнэлгийн газар, Тамгын газрын нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн. 2. Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын А/202, сумын Засаг даргын "Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/40 дугаар захирамжийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. . Энэ онд төлөвлөгөөт Дотрын халдварт хордлого, Галзуу, Шөвөг яр, Цусан халдварт, Боом зэрэг 5 төрлийн дархлаажуулалтад 9.8 мянган толгой мал сүрэг хамрагдахаас 3850 мянган толгой мал дархлаажуулалтад хамрагдаад байна. 3. . . Сумын ИТ-н 2022 оны 12 дугаар сарын 16-ны ээлжит хуралдаанаар сумын шимэгчтэх өвчний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөг МЭНС-д оруулан ажиллаж байна. Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 110900 мал хамрагдана. | | |
| 49 | | 3.2.2. Малын шилжилт хөдөлгөөн болон | 2021 - 2024 | 0 | | Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/36 дугаар "Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох тухай" | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулна. | | | | захирамжийн дагуу сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/08 дугаар захирамжийг боловсруулан батлууллаа. Захирамжийг нэгдсэн page групп болон багуудын групп, Шинэжинст суман дахь Мал эмнэлгийн тасаг групп дээр тавьж мэдээллийг хүргэлээ. Мөн 02 дугаар сарын 4,5-ны өдөр зохион байгуулагдсан малчид, төлчдийн зөвлөгөөнөөр аймаг, сумын Засаг даргын захирамжийг танилцууллаа. Шилжилт хөдөлгөөнөөр өөр аймгаас ирж байгаа адуунд бичигдсэн цахим гэрчилгээнд хянан зөвшөөрөх төлөв оруулан ирэхэд нь хүлээн авч халдваргүйтгэн цусны дээж аван аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэн ажиллаж байна. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд Мал эмнэлгийн цахим гэрчилгээг үндэслэн хяналт тавьж ажиллаж байна. | | |
| 50 | | 3.2.3. Мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлнэ. | 2021 - 2024 | 2.5 | | Халдваргүйтгэлийн бодис-200кг, Халдвар хамгаалллын хувцас-60 ширхэг нөөц бүрдүүлсэн. | 70% | 70% |
| 51 | 3.3. Малын чанар ашиг шимийг сайжруулах | 3.3.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулах малын тоог чанарт шилжүүлж "Монгол мал" "Монгол малчин", "Шинэ хөдөө" үндэсний хөтөлбөрийг | 2021 - 2024 | | | Монгол малчин хөтөлбөрийн хүрээнд малчдыг мэдээллээр хангах, мэдлэгжүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтэгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоонд чанарын үнэлэмж бий болгох, малчид, малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх,орлого ашгийг өсгөх, эдийн засгийн чадамжийг сайжруулах, хамтын хоршил, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, байгальд ээлтэй, хариуцлагатай мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд чиглэсэн арга хэмжээг | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлнэ. | | | | хэрэгжүүлэх,орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл нийгмийн баталгааг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Шинэ хөдөө төслийн хүрээнд иргэдийг ажилтай, орлоготой болгох, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байр бий болгох, малын чанарыг сайжруулах,ашиг шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор Баянбулаг омгийн өсвөр 25 толгой хуц хургыг нийлүүлэхээр гэрээ хийн бойжуулж байна. | | |
| 52 | | 3.3.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт болон үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэн, бренд бүтээгдэхүүн бий болгоно. | 2021 - 2024 | | | Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох ноос ноолуур,сүү сүүн бүтэгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хоршоодод зээл олгох, хоршоод Засгийн газрын хөнгөлөлттэй зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлж байна.Зарим хоршоод бүтэгдэхүүнээ гадаад зах зээлд гаргах экспортлоход нь дэмжлэг үзүүлж төсөл хөтөлбөртэй хамтран цөм сүргийн малыг бий болгож,түүнээс шилдэг хээлтэгч, хээлтүүлэгчийг бойжуулан хоршооны бусад өрхийн мал сүргийг сайжруулах ажлыг эхлүүлээд байна.Цаашид ноолууран бүтээгдэхүүнийг орон нутгийн брэнд бүтээгдэхүүнээр тодорхойлуулах ажлыг зорилго болгож байна. | 70% | 70% |
| 53 | | 3.3.3. Төсөл хөтөлбөрийн хүрээнд малжуулах ажлыг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | 5,0 | | Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газраас ирүүлсэн албан бичгийн зар мэдээг сумын малчин өрхүүдэд хүргэн хүсэлтийг авч ажлын хэсэг шалгаруулалтыг хийн хүргүүллээ. Мөн тогтвортой ноолуур төслийн санхүүжилтээр цөм сүрэг бий болгон 2 дугаар багийн малчин Ш.Жигжидсүрэнд хариулгаж төл болон онд оролтоос тодорхой тооны малаар малжуулах арга хэмжээ авч байна. | 50% | 50% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 3.4. Үйлдвэржилтийн бодлогын судалгаан дээр үндэслэн сумын үйлдвэржилтийн бодлогыг тодорхойлж зах зээлийг судлах, цаашид эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх | 3.4.1. Үйлдвэржилтийн бодлоготой уялдуулж орон нутгийн чиглэлийг тодорхойлж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | 100000000 | | Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар 45 тоот тогтоолоор баталсан. 2022 онд 2 хоршоонд Хоршоо хөгжүүлэх сангаас 100 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. | 70% | 70% |
| 55 | | 3.4.2. Ингэ ямааний сүү хуурайшуулах үйлдвэр байгуулах мөн арьс шир, нэхий боловсруулах анхан шатны цехийн үйл ажиллагааг сайжруулан байнгын ажиллагаатай болгоно. | 2021 - 2024 | | | Ингэний сүүний үйлдвэрийг байгуулах ажлыг аймагт эхлүүлж барилгын ажил хийгдэж, лаборатори байгуулагдан ферм байгуулах ажил сумдад судалгаа хийгдэж 4 ферм байгуулах төлөвлөгөө гарсан.Манай сумандодоогийн байдлаар ферм байгуулахаар малчны хоршоо байгуулагдаад байна. | 50% | 50% |
| 56 | 3.5. Санхүү эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна | 3.5.1. Татварын хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтэд хяналт тавих, улс орон нутгийн төсвийн орлогыг татварын нэр төрөл бүрээр | 2021 - 2024 | Үйл ажиллагааны зардлаар | | Татвар төлөгчдөд мэдлэг олгох, мэдээлэл хүргэхээр Татварын багц хуулийн талаар, цахимаар тайлангаа илгээх заавар, хугацаа, татвараа цахимаар төлөх болон бусад эрхзүйн мэдээ мэдээллийг цахимаар сурталчлан ажилладаг. Өдөрт 3-5 мэдээллийг Залаажинст, Татварын мэдээлэл-Шинэжинст сум группээр сурталчлан ажиллалаа. Мөн иргэний эрхзүйн мэдээллийн цагаар 68, Хоршооны хурлаар 100 гаруй өрхийн | 90% | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жигд ханган биелүүлнэ. | | | | төлөөлөлд ХХОАТ-ын тухай хууль, АТБӨЯХАТ-ын тухай хууль, Ибаримтын талаар, Иргэний эрхзүйн мэдээллийн цагаар Татварын цахим шинэчлэл сэдвээр сургалт хийн 84 хүн хамрагдсан. Улс орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор татварын орлого бүрдүүлдэг албан хаагчидтай хамтран ажиллалаа. Энэ оны эхний 5 сарын байдлаар улсын төсөвт 3180.4 мян.төг-ийн орлого төвлөрүүлэн ажилласан. Сумын төсөвт эхний 5 сарын байдлаар 91260.0мян.төг-ийн орлого төвлөрүүлэхээс 180497.6 мян.төг-ийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөний тэнцлийг 198 хувиар ханган биелүүлсэн. | | |
| 57 | | 3.5.2. Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хэрэглээг иргэдэд сурталчлан таниулж, “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтаар зарлаж, шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь нягтлан бодогч нар хариуцан мэдээлж байна. Төсөвт байгууллагуудын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн аудитлагдсан тайланг Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн байгууллагууд байгууллагын ажилчдын хурлаар хэлэлцүүлсэн. | 70% | 70% |
| 58 | | 3.5.3. Байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, ажилчдыг | 2021 - 2024 | | | Төсөвт байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, байгууллага бүр нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт, анхан шатны баримтын бүрдэл ханган Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан маягтаар Аймгийн Засаг даргын | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чадавхижуулан стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана. | | | | 683 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Санхүүгийн албыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран орчин үеийн суурин компьютер, сейфээр ханган ажиллаж байна. Цаашид төрийн албан хаагчдыг ээлж дараатайгаар Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан техник хэрэгслээр хангах бодлого баримталж байна. | | |
| 59 | | 3.5.4. Төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан хяналт тавина. | 2021 - 2024 | | | Төсөвт газрууд эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж байна. Цаашид тооллогын дүнг байгууллагын даргаар баталгаажуулах хөрөнгө эзэмшигчдийн хөрөнгийн хариуцлагын гэрээг шинэчлэн хийх, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн ажлуудад хяналт тавих шаардлагатай. | 50% | 50% |
| 60 | | 3.5.5. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхжүүлэн оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. | 2021 - 2024 | | | Тус суманд “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төсөл амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд булгийн эх хамгаалах ажлыг санхүүжүүлж “Задгай” булгийн эхийг хамгаалсан. “Цоохондойт уулынхан” ТББ-д зэрлэг ан амьтан хамгаалах 17 сая төгрөгийн санхүүжилт олгож мониторинг судалгааны багажаар хангасан. 2023 онд хийгдэх ажлын санал, төлөвлөгөө гарсан бөгөөд одоогоор “Хаяа” булгийн эхийг хамгаалах ажлын саналыг авч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Хурга махлуулах ажлыг туршилтаар 3 айлд хийж ажиллаж байна. Мал үржлийн стратеги төлөвлөгөөг гаргаж өгсөн бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулан мөрдөж байна. | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4. ДӨРӨВ. Засаглалын бодлого | | | | |
| 61 | 4.1. Төрийн албаны үйлчилгээг түргэн шуурхай болгож, иргэдийг төрийн нэгдсэн бодлого удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлж, төрийн албанд ёс зүй, чадахуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулна. | 4.1.1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | 2021 - 2024 | төсвөөс | | Багш ажилчдын улирлын үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон үнэлж байна. Ёс зүйн алдаа дутагдал гаргасан албан хаагчийг ёс зүйн зөвлөлийн хурлаар оруулан алдаа дутагдлыг засаж хариуцлага хүлээлгэн хэвшсэн. 2023 оны хагас жилийн байдлаар алдаа дутагдал гаргасан албан хаагч байхгүй байна. | 90% | 90% |
| 62 | | 4.1.2. Чадварлаг, хариуцлага, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ. | 2021 - 2024 | | | Долоо хоног бүрийн 3 дахь өдрийн 17:00 цагаас Ёс зүй, Хууль эрх зүйн мэдлэг олгох Мэдээллийн цагийг төрийн албан хаагчид болон ард иргэдэд хийж хэвшсэн ба 2023 оны 01 сараас хойш 18 удаагийн сургалт зохион байгуулагдсан байна. | 50% | 50% |
| 63 | | 4.1.3. Төрийн үйлчилгээний операторын үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн байгуулагын үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт | 2021 - 2024 | | | Сум орон нутагт иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй хурдан шуурхай хүргэхийн тулд имонголиад нэвтрэх эрхийг нээж өгөх, заавар зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж байна. - 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Баянхонгор аймагт сургалтад хамрагдаж, операторын эрхээ нээлгэж, тоон гарын үсгийн токен төхөөрөмжөө өөрийн нэр дээр шилжүүлж авсан. Ингэснээр өөрийн ажлыг бүрэн гүйцэд, түргэн шуурхай явуулах боломж бүрдсэн. - 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр ард иргэд болон төрийн албан хаагчдад нийт 57 | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | технологи, инноваци нэвтрүүлэх замаар төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. | | | | хүнд Emongolia хэрхэн нээх, лавлагаа тодорхойлолт операторчоос хэрхэн авах талаар мэдээлэл хийсэн. Сургалтад хамрагдахаас өмнө нийт 6 хүнд emongoliad нэвтрэх эрхийг нээж өгсөн бөгөөд сургалтаас хойш 2 сарын хугацаанд нийт 36 хүнд emongoliad нэвтрэх эрхийг нээж өгч, утсан дээр оруулж хадгалж өгсөн. Операторын эрхээр нийт 15 хүнд лавлагаа гаргаж өгсөн байна. . Бусад тохиолдолд нууц үг хэрхэн сэргээх, бүртгэлтэй дугаарыг хэрхэн солих гэх мэтээр заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн өөрсдийн албаны фейсбүүк хуудсуудаар мэдээлэл оруулж ажиллаж байна. | | |
| 64 | | 4.1.4. Мэргэжлийн болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | 2021 - 2024 | | | Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулж 37 заалтай Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн ээлжит 1 дугаар хуралдааны 84 дугаар тогтоолын хавсралт дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна | 50% | 50% |
| 65 | | 4.1.5. Төрийн байгууллагуудын авто машины парк шинэчлэлтийг хийнэ. | 2021 - 2024 | нийт хөрөнгө 148,800,0000 | | Сумын эрүүл мэндийн төвд Эрдэнэмонгол ХХК-аас 80,000,000 сая төгрөг УАЗ Фурган авто машин ОНХС Мал эмнэлгийн дүп машиныг 68,800,000 авто машины парк шинэчлэлтийг хийж хүлээлгэн өгсөн байна | 100% | 100% |
| 66 | | 4.1.6. Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэн бүх нийтийн хандлагыг | 2021 - 2024 | | | Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын "Авлигатай тэмцэх газар" пэйж хуудсыг, "АТГ-Олон нийтийн төв" Фейсбүүк пэйж хуудсыг байгууллагынхаа нийт албан хаагч болон иргэдэд сурталчилж, нэгдэн дагах ажлыг зохион байгуулан идэвхтэй хамруулан дээрх | 50% | 50% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өөрчилнө. | | | | пэйж хуудсуудаар дамжуулан мэдээ, мэдээллийг аван ажиллаж байна. | | |
| 67 | | 4.1.7. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж иргэдэд эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | | | Долоо хоног бүрийн 3 дахь өдрийн 17:00 цагаас Хууль эрх зүйн мэдлэг олгох Мэдээллийн цагийг төрийн албан хаагчид болон ард иргэдэд хийж хэвшсэн ба 2023 оны 01 сараас хойш 18 удаагийн сургалт зохион байгуулагдсан байна. | 70% | 70% |
| 68 | | 4.1.8. Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2024 | | | Хамааралгүй заалт | 0% | 0% |
| 69 | | 4.1.9. Сумын Спорт заал, Эрүүл мэндийн төвийн ажилчдын барилгуудад их засвар хийх , ЗДТГазрын барилгыг шинээр барих ажлыг хийнэ. | 2021 - 2024 | Улсын төсөвын хөрөнгө оруулалтаар спорт заал төсөв 680 сая | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сумын Спорт заалыг Баянхонгор аймгийн Буян Аривжих од ХХК шалгарч улсын комисст хүлээлгэн өгөхөд билэн болсон байна Эрүүл мэндийн төвийн ажилчдын барилгуудад их засвар хийх, ЗДТГазрын барилгыг шинээр барих ажил хүлээгдэж байна | 50% | 50% |
| 70 | | 4.1.10. Сумын төв доторх 2 км хатуу хучилттай зам тавих ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2024 | | | Хүлээгдэж байгаа. | 0% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 71 | | 4.1.11. Төрийн албаны мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцийг чадавхижуулна. | 2021 - 2024 | | | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана ажиллаж байна. Үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулж ажиллахын тулд Сумын цахим веб сайт болон Фейсбүүк фэйж нээн Төрийн байгууллагаас зохиогдож буй үйл ажиллагаа, төсөв санхүүгийн талаарх ажлуудыг олон нийтэд ил тод байршуулан ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээний газар байгуулагдсантай холбогдуулан Төрийн үйлчилгээний операторын орон тоог 2023 оны 01 сарын 02-ны Б/02 тушаалаар батлан ажиллаж байна. Мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулахын тулд 2023 оны 04 сарын 18, 19-ний өдрүүдэд ажил, мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө авах сургалтад хамруулсан. Ингэснээр ажилтан 04 сарын 26-ны өдөр ард, иргэд болон төрийн албан хаагчдад имонголиа хэрхэн нээх, лавлагаа тодорхойлолт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө хийж ажиллаж байна. | 70% | 70% |
| 72 | | 4.1.12. Эхийн голыг эрчим хүчээр хангах | 2021 - 2024 | | | хүлээгдэж байна. | 0% | 0% |
| 73 | 4.2. Архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангаж албан хэрэг хөтлөлтийн үйл | 4.2.1. Төрийн байгууллагуудын архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд | 2021 - 2024 | төсвөөс | | Аймгийн төрийн архивын баримт хүлээн авах хуваарийн дагуу 4 дүгээр сарын 25-наас эхлэн төрийн архивд байгууллагын 2020 оны цаасан болон цахим баримтыг хүлээлгэн өгсөн. | 100% | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг цахимжуулна. | архивын баримтын нягтруулсан шүүгээтэй болсон байна. | | | | | | |
| 5. Тав: Ногоон хөгжлийн бодлого | | | | | | | | |
| 74 | 5.1. Байгаль орчныг хамгаалах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 5.1.1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийнэ. | 2021 - 2024 | | | Уст цэгийн хайгуулыг Чинзориг захиралтай "Гео процессинг дата " ХХК гүйцэтгэж 2 цооног өрөмдөх бөгөөд орон нутгийн хөгжлийн сангаас 20 сая төгрөгийг зарцуулсан байна. | 70% | 70% |
| 75 | | 5.1.2. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээнэ. | 2021 - 2024 | | | Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр Байгаль орчин аялал жуулчлалын яамны салбарын улсын байцаагчийн баталсан 01/10 дугаарын удирдамжийн дагуу 2 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, албан шаардлагыг 2 аж ахуйн нэгжид өгч хэрэгжилтийг хангууллаа. | 50% | 50% |
| 76 | | 5.1.3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлнэ. | 2021 - 2024 | | | Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр иргэдэд мэдээллийн цагаар 2 удаа сургалт хийж нийт 210 иргэн хамрагдсан байна. “Залаажинст”, “Шинэжинст сумын байгаль” зэрэг хандалт олонтой, сумын олон нийтийн сүлжээгээр танин мэдэхүйн мэдээлэл, шторкийг 7 хоногт 2 удаагийн давтамжтайгаар аялуулж ажиллаж хэвшсэн. | 70% | 70% |
| 77 | | 5.1.4. “Хоггүй Шинэжинст” аяныг зохион | 2021 - 2024 | | | “Хоггүй Шинэжинст” аяны хүрээнд хог хаягдлын цэгийг дарж булшлах, шинээр байгуулах төслийг боловсруулж ажилласан | 50% | 50% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангана. | | | | бөгөөд хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлүүлэн, гэрээ байгуулсан бөгөөд гүйцэтгэгч аж ахуйн нэгж ирэх 7 дугаар сард үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөсөн байна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулагдсан бөгөөд хэрэгжилтийг хангах чиглэлээр сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/16 дугаарын захирамж гарган дагаж мөрдөж ажиллаж байна. | | |
| 78 | | 5.1.5. Зэрлэг амьтдыг хамгаалах, өвс тэжээлийн хомсдлоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад био техникийн арга хэмжээ авна. | 2021 - 2024 | | | Зэрлэг амьтдыг хамгаалах, өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр энэ оны хагас жилд Засаг даргын Тамгын газраас зэрлэг амьтны байршил бүхий газруудад био техникийн арга хэмжээг 3 удаа авч, 140 боодол өвсийг 8 цэгт 2 машин 25 хүний оролцоотойгоор, 3800000 орчим төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж ажиллалаа. “Цоохондойт уулынхан” ТББ нь зэрлэг ан амьтан хамгаалах чиглэлээр ENSURE төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зэрлэг ан амьтны байршил бүхий газарт 3 удаа 2 цэгт 100 боодол өвс , 20 кг хужир мараа тавих ажлыг гүйцэтгэн, тайлан мэдээг ирүүлсэн байна. | 90% | 90% |
| 79 | | 5.1.6. 6 Булгийн эхийг хамгаалах ундрагыг сэргээх ажлыг иргэд, малчид, нөхөрлөлийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Булгийн эхийг хамгаалах чиглэлээр Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу сумын нутаг дахь биологийн олон янз байдлын хувьд ач холбогдол бүхий Уртын гол 2 дугаар багийн нутаг “Хаяа” булгийн эхийг хамгаалах ажлын гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын | 70% | 70% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагаас сонгон шалгаруулж, сумын Засаг даргатай гэрээ байгуулсан бөгөөд төслөөс санхүүжилтийг хүлээж байна. | | |
| 80 | | 5.1.7. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хяналтыг сайжруулна. | 2021 - 2024 | | | Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хяналтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан. Хяналт шалгалтыг хийх ажлын удирдамжийг ахлах улсын байцаагч батлан ирүүлсэн. Уг удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийх бэлтгэл үеийг хангаад байна. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль хамгаалагчид 7 хоног тутамд хээрийн эргүүл хяналтыг тогтмол хийж байна. Гарсан зөрчилгүй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудаас “Эрдэнэмонгол” ХХК хайгуулын үйл ажиллагаа эхэлсэн явагдаж байгаа бөгөөд уг газарт зөрчил байна гэх мэдээлэл хүсэлт 1 ирсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг “Эрдэнэмонгол” ХХК , Анион ресорсиз ХХК, "Баянхөхтолгой" ХХК-уудын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэж, дутагдлыг арилгуулах чиглэлээр 2 албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. | 70% | 70% |
| 81 | | 5.1.8. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулна. | 2021 - 2024 | | | Ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллаж байна. Хамгаалалтын бүс тэмдэгжүүлэгдсэн байна. Ундны ус цэгийг тохижуулах, цэвэр бохир усны шугамыг тавих, холболт хийх ажил хийгдэж эхэлсэн явцтай байна. | 50% | 50% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 82 | | 5.1.9. Орон нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технилогийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Сум орон нутгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр явах маршрутыг олон нийтийн санал, бодлыг тусгаж гаргасан байна. Монголд зочлох жилийн хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын газраас сумын онцлог газруудын судалгааг авч Хятад улсаас аялагчид Гурвантэс сумаас Шинэжинст сумын нутгаар аялаад буцах маршрутыг гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж ажилласан байна. | 50% | 50% |
| 83 | | 5.1.10. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг эмх цэгцтэй, бодит байдлаар хийж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Жишиг гудамж” хороолол арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг эмх цэгцтэй, бодит байдлаар хийж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Жишиг гудамж” хороолол арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор Монголд зочлох жилийн хүрээнд айл өрхүүдийн дунд жишиг хашаатай болох уралдаан зарлан ажиллаж байна. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | 50% | 50% |
| 6. Зургаа: Амар тайван, аюулгүй нийгмийн бодлого | | | | | | | | |
| 84 | 6.1. Иргэдийн амар тайван байдлыг хангах | 6.1.1. Сумын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлж хяналтыг сайжруулна. | 2021 - 2024 | | | Төрийн 86 албан хаагчдад Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Цахим гэмт хэрэг, бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 80 сурагчдад Тамхины хор хөнөөл, Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хүүхдийн эрхийн талаар сургалтыг 1 удаа, багуудын Иргэдийн нийтийн хурлаар 250 гаруй малчид, ард иргэдэд шинээр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын талаар сургалт орж гарын авлага материал тараалаа. Гэмт | 30% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэргийн тоо урьд онд 4 байсан бол энэ оны хагас жилийн байдлын 4 бүртгэгдсэн байна. | | |
| 85 | | 6.1.2. Малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, хамтран ажиллана. | 2021 - 2024 | | | Шинэжинст сумын хэмжээнд хөдөөгийн 3баг, сумын төвийн 1 багт хуваагдан төрийн үйлчилгээг ард түмэнд хүргэж ажиллаж байна. Зараа баг 4 бүлэгт, Эрдэнэшанд баг 7 бүлэгт, Уртын гол 9 бүлэгт хуваагдан бэлчээрийг зөв зохистой ашиглах бүлгээрээ нийлэн худаг ус засварлах тохижуулах, өвөлжөө хаваржааны хашаа хороог шинэчлэх барьж байгуулах, тохижуулах зэрэг ажлуудыг хийхийн зэрэгцээ бүлгүүдийн хооронд зохион байгуулдаг урлаг спортын уралдаан тэмцээнүүдэд идэвхтэй оролцдог. Эхэн хавцгай баг нь хороолол гудамжаараа нэгдэн орчны хог хаягдал цэвэрлэх, гудамж талбайн гэрэлтүүлэгт анхаарал тавих эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх талаар хамтран ажилладаг. | 70% | 70% |
| 86 | | 6.1.3. Малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, хамтран ажиллана. | 2021 - 2024 | | | Шинэжинст сумын хэмжээнд хөдөөгийн 3 баг, сумын төвийн 1 багт хуваагдан төрийн үйлчилгээг ард түмэнд хүргэж ажиллаж байна. Зараа баг 4 бүлэгт, Эрдэнэшанд баг 7 бүлэгт, Уртын гол 9 бүлэгт хуваагдан бэлчээрийг зөв зохистой ашиглах бүлгээрээ нийлэн худаг ус засварлах тохижуулах, өвөлжөө хаваржааны хашаа хороог шинэчлэх барьж байгуулах, тохижуулах зэрэг ажлуудыг хийхийн зэрэгцээ бүлгүүдийн хооронд зохион байгуулдаг урлаг спортын уралдаан тэмцээнүүдэд идэвхтэй оролцдог. Эхэн хавцгай баг нь хороолол гудамжаараа нэгдэн орчны хог хаягдал цэвэрлэх, гудамж талбайн гэрэлтүүлэгт анхаарал тавих эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх талаар хамтран ажилладаг. | 70% | 70% |
| 87 | | 6.1.4. Сумын хэмжээний | 2021 - 2024 | | | Одоогоор Жаргалтай амьдрал төвд явсан иргэн байхгүй. Хойшид анхаарч ажиллана. | 0% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | архины хамааралтай иргэдийг соён гэгээрүүлэх үүднээс “Жаргалтай амьдрал төв”-тэй хамтран ажиллана. | | | | | | |
| 88 | 6.1. Иргэдийн амар тайван байдлыг хангах | 6.1.5. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | 2021 - 2024 | | | Гэр бүлийн хүчирхийллийн тоог бууруулах урьдчилан сэргийлэх зорилгоор сургалтуудыг зохион байгуулж ажилласан. Гэр бүл хүүхэд залуучуудын газраас 2 мэргэжилтэн 2 удаа, сумын нийгмийн бодлогын ажилтан 2 удаа нийт 4 удаагийн сургалт мэдээллийг хийж 280 иргэн хамрагдсан байна. | 50% | 50% |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ

# ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Өөрийн үнэлгээ)

2023 оны 06 дугаар сарын 20

Залаа

| ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 88 | | | |
| Үнэлгээс | Үр дүнтэй | **100%** | **9** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **54** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **18** |
| | Үр дүнгүй | **0%** | **7** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | - |
| | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт **65%** хувьтай байна. | | |

_________________________оОо_________________________

# ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2023 оны 06 дугаар сарын 20

Залаа

| ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 88 | | | |
| Үнээс | Үр дүнтэй | **100%** | **5** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **54** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **18** |
| | Үр дүнгүй | **0%** | **11** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | |
| | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт **60%** хувьтай байна. | | |

_________________________оОо_________________________